

Монгол улс - Хүүхэд хөгжил судалгаа 2010

Үндэсний статистикийн хороо - ҮСХ

Үүссэн огноо: June 23, 2014

Вэб хуудас: <http://web.nso.mn/nadamn/index.php>

Тойм

Тодорхойлолт

ДУГААР

MNG-NSO-MN-MICS2010-v3.0

Хувилбар

ХУВИЛБАРЫН ТАЙЛБАР

Хувилбар 1.1: Үндсэн үр дүнгийн тайлан гаргахад ашигласан засварлагдсан мэдээллийн сан

ҮҮССЭН ОГНОО

2012-09-30

Тойм

ТОВЧ

Судалгааны зорилго нь Монгол Улсын хүүхэд, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол, хөгжил, хамгаалал, аж байдал, тэдний эрхийн хэрэгжилт болон эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага, бэлгийн зан үйлийн талаарх статистик тоо мэдээллийг гаргах, өмнөх судалгааны мэдээллийг шинэчлэх, баяжуулах, дэлхийн дээд хэмжээний “Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц” тунхаглал, Мянганы хөгжлийн зорилт болон Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлж байгаа “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийг дүгнэх, үнэлгээ өгөхөд чиглэгдсэн юм.

Тус судалгааны мэдээлэл нь үндэсний бодлого, хөтөлбөр боловсруулагчид, олон улсын байгууллага болон бусад хэрэглэгчдэд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээгээ тодорхойлох, төсвийн хуваарилалтыг оновчтой хийх зэрэгт ашиглагдах үнэ цэнэтэй суурь мэдээлэл болж өгөх юм.

Үндсэн зорилгынхоо хүрээнд дараах 6 зорилт тавин ажиллалаа.

1.5 хүртэлх насны хүүхдийн хоол тэжээл, өвчлөл, дархлаажуулалт, хөгжил, хүмүүжил, хамгаалал, орчин нөхцөл, тэдний эрхийн хэрэгжилтийг тодорхойлох;

2.Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, хөгжлийн бэрхшээл, осол, гэмтлийн талаарх статистик мэдээллийг цуглуулах;

3.Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн боловсрол, эрүүл мэнд, мэдээллийн технологийн хэрэглээ, тамхи, архи, согтууруулах ундааны хэрэглээ, ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага, дадал, бэлгийн зан үйлийн талаарх статистик мэдээллийг цуглуулах;

4.НҮБ-ын тусгай чуулганаар 2002 онд баталсан “Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц” хөтөлбөрийг үнэлэх 50 шалгуур үзүүлэлтээс 19 үзүүлэлтийг тооцох;

5.Монгол Улсын Засгийн газраас 2002 онд баталсан “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг үнэлэх 28 шалгуур үзүүлэлтээс 9 үзүүлэлтийг тооцох;

6.Монгол Улсын Их Хурлын 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 13 тоот тогтоолоор батлагдсан Мянганы хөгжлийн зорилтын хэрэгжилтийг үнэлэх 67 шалгуур үзүүлэлтээс 14 үзүүлэлтийг тооцох.

МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ

Sample survey data [ssd]

СУДАЛГААНЫ НЭГЖ

Өрх (нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүс)

Өрхийн гишүүд(хоорондоо гэр бүл, ураг төрөл болон хамаатан садны холбоотой болон холбоогүй тухайн өрхөд амьдарч, хамт хооллодог хүмүүс.)

15-49 настай эмэтэйчүүд

15-54 настай эрэгтэйчүүд

0-4 настай хүүхдийн эх/асрамжлагч

2-14 настай хүүхдийн эх/асрамжлагч

Хүрээ

ТЭМДЭГЛЭЛҮҮД

Хүүхэд хөгжил - 2010 судалгааны үзүүлэлтүүд:

ӨРХИЙН АСУУЛГА:

- Хаягийн хэсэг,
- Өрхийн гишүүдийн ерөнхий мэдээлэл,
- Өрхийн гишүүдийн боловсрол,
- Ус болон ариун цэврийн байгууламжийн хангамж,
- Өрхийн зарим үзүүлэлт,
- 5-17 настай хүүхдийн хөдөлмөр эрхлэлт,
- 2-14 настай хүүхдийн хүмүүжил,
- Гар угаах газар,
- Иоджуулсан давсны хэрэглээ.

15-49 НАСНЫ ЭМЭГТЭЙН АСУУЛГА:

- Хаягийн хэсэг,
- Эмэгтэйн ерөнхий мэдээлэл,
- Олон нийтийн мэдээллийн хэрэгслэлийн хүртээмж болон мэдээлэл, харилцааны технологийн хэрэглээ,
- Хүүхдийн эндэгдэл,
- Хүсээгүй жирэмслэлт,
- Эх, нялхсын эрүүл мэнд,
- Өвчлөлийн шинж тэмдэг,
- Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслэлийн хэрэглээ, мэдлэг,
- Жирэмснээс сэргийлэх арга, хэрэгслийн хэрэгцээ,
- Гэрлэлтийн байдал,
- Гэр бүлийн хүчирхийлэлд хандах хандлага,
- Бэлгийн харьцааны төлөвшил,
- ХДХВ/ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага,

- Тамхи, согтууруулах ундааны хэрэглээ,

- Амьдралын сэтгэл ханамж.

15-54 НАСНЫ ЭРЭГТЭЙН АСУУЛГА:

- Хаягийн хэсэг,

- Эрэгтэйн ерөнхий мэдээлэл,

- Олон нийтийн мэдээллийн хэрэгслэлийн хүртээмж болон мэдээлэл, харилцааны технологийн хэрэглээ,

- Нөхөн үржихүй,

- Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслэлийн хэрэглээ, мэдлэг,

- Гэрлэлтийн байдал,

- Гэр бүл төлөвлөлт

- Хүйсийн тэгш эрх,

- Бэлгийн харьцааны төлөвшил,

- ХДХВ/ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага,

- Тамхи, согтууруулах ундааны хэрэглээ,

- Амьдралын сэтгэл ханамж.

5 ХҮРТЛЭХ НАСНЫ ХҮҮХДИЙН АСУУЛГА:

- Хаягийн хэсэг,

- Нас,

- Төрсний бүртгэл,

- Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжил,

- Эхийн сүүгээр хооллолт,

- Хүүхдийн өвчлөл, эмчилгээ, сувилгаа,

- Вакцинжуулалт,

- Хүүхдийн жин, өндрийн хэмжилт.

2-14 НАСНЫ ХҮҮХДИЙН АСУУЛГА:

- Хаягийн хэсэг,

- Хүүхдийн осол, гэмтэл,

- Хүүхдийн хөгжлийн бэрхшээл.

TOPICS

Агуулга	Үгийн сан	URI
Household members	MICS HH Topics	
Water and sanitation	MICS HH Topics	

Агуулга	Үгийн сан	URI
Household characteristics	MICS HH Topics	
Child labour	MICS HH Topics	
Child discipline	MICS HH Topics	
Hand washing	MICS HH Topics	
Salt iodization	MICS HH Topics	
Women's background	MICS Woman Topics	
Child mortality	MICS Woman Topics	
Desire for last birth	MICS Woman Topics	
Maternal and newborn health	MICS Woman Topics	
Illness symptoms	MICS Woman Topics	
Contraception	MICS Woman Topics	
Unmet need	MICS Woman Topics	
Marriage/union	MICS Woman Topics	
Sexual behaviour	MICS Woman Topics	
Children's age	MICS Child Topics	
Birth registration	MICS Child Topics	
Early childhood development	MICS Child Topics	
Breastfeeding	MICS Child Topics	
Care of illness	MICS Child Topics	
Malaria	MICS Child Topics	
Immunization	MICS Child Topics	
Anthropometry	MICS Child Topics	
Men's background	MICS Man Topics	
Reproduction	MICS Man Topics	
Contraception	MICS Man Topics	
Marriage/union	MICS Man Topics	
Sexual behaviour	MICS Man Topics	
Fertility preference	MICS Man Topics	
Gender equity	MICS Man Topics	
Tobacco and alcohol use	MICS Man Topics	
Life satisfaction	MICS Man Topics	

Ажиглалтын хүрээ

ГАЗАР ЗҮЙН ХҮРЭЭ

Хүүхэд хөгжил судалгаа-2010 бол Монгол улсыг бүхэлд л хамарсан үндэсний хэмжээний, хот, хөдөө, бүс(Таван бүс - Баруун, Хангай, Төв, Зүүн, Улаанбаатар)-ийн хэмжээнд зохион байгуулагдсан судалгаа юм.

ХҮРЭЭ

Өрхөд байнга оршин суудаг хүмүүс өрхийн асуулгад хамрагдсан бөгөөд ганцаарчилсан ярилцлагад 15-49 насны эмэгтэй, 15-54 насны эрэгтэй, 5 хүртэлх насны хүүхдийн эх/ асран хамгаалагч болон 2-14 насны хүүхдүүд, тэдний эх/

асран хамгаалагчид хамрагдсан юм.

Гүйцэтгэгч болон түнш

АНХНЫ ШИНЖЭЭЧ

Нэр	Харьяалал
Үндэсний статистикийн хороо	ҮСХ

БУСАД ГҮЙЦЭТГЭГЧ

Нэр	Харьяалал	Үүрэг
Үндэсний статистикийн хороо	Монгол Улсын Их хурал	Судалгааг зохион байгуулж хяналт тавьж ажилласан
Монгол улс дах НҮБ-ын Хүүхдийн Сан	Нэгдсэн Үндэстний байгууллага	Судалгааг зохион байгуулахад техникийн зөвөлгөө өгсөн.
НҮБ-ын Хүүхдийн сангийн ОУБТС-ны зохицуулагч	Нэгдсэн Үндэстний байгууллага	Олон улсын техникийн зөвөлгөө өгсөн.

САНХҮҮЖИЛТ

Нэр	Товчлол	Үүрэг
НҮБ-ын Хүүхдийн Сан	НҮБХС	Судалгааг санхүүжүүлсэн
Монгол улсын Засгийн газар	Монгол улс	Судалгааг санхүүжүүлсэн

Мета мэдээлэл боловсруулалт

БОЛОВСРУУЛСАН

Нэр	Товчлол	Харьяалал	Үүрэг
Үндэсний Статистикийн Хороо	ҮСХ	УИХ	Судалгааны бичиг баримт
А.Булганчимэг		Гэрээт ажилтан	Мета мэдээллийн баримтжуулалт хийсэн
НҮБХС-ын ОУБТС-ны бүсийн зохицуулагч		НҮБХС	Мета мэдээллийг хянаж засварласан
НҮБХС-ын ОУБТС-ны үндэсний зөвлөх		НҮБХС	Мета мэдээллийг хянаж засварласан

МЕТА МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛСАН ОГНОО

2012-09-19

DDI БИЧИГ БАРИМТЫН ХУВИЛБАР

Хувилбар 2.1(2012 оны 9-р сар)

DDI БИЧИГ БАРИМТЫН ДУГААР

MNG-NSO-MN-MICS2010-v3.0

Түүвэрлэлт

Түүвэрлэлт

Монгол Улсын “Хүүхэд хөгжил 2010” судалгааны үр дүнд тооцогдох үндсэн үзүүлэлтүүдийг статистикийн хувьд бодитой байдлаар үндэсний түвшинд тооцохоос гадна хот, хөдөөгөөр болон бүсээр (Баруун, Хангай, Төв, Зүүн, Улаанбаатар) тооцох зорилгоор түүврийн зохиомжийг боловсруулсан. Таван бүсийг дотор нь хот, хөдөөгөөр түүврийн бүлэг (strata) болголоо. Судалгаанд хамрагдах өрхүүдийг сонгохдоо хоёр шатлалт бүлэглэсэн түүврийн аргыг ашигласан.

Түүврийн хэмжээ болон түүний хуваарилалт.

Энэ удаагийн “Хүүхэд хөгжил 2010” судалгааны түүврийн хэмжээг бүс бүрийн хувьд 2100 өрх, улсын хэмжээнд нийт 10500 өрх байхаар тооцсон. Түүврийн хэмжээг тооцохдоо “Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан 3-4 насны хүүхдийн хувь” гэсэн үзүүлэлтийг түлхүүр үзүүлэлт болгон сонгон авсан.

Өмнөх судалгаа буюу “Хүүхэд хөгжил 2005” судалгааны үр дүнгээс үзэхэд 3-4 насны хүүхдийн хувьд сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан байдал улсын хэмжээнд 37 хувьтай байсан бол Баруун бүсэд 32, Хангайн бүсэд 32, Төвийн бүсэд 33, Зүүн бүсэд 40, Улаанбаатар хотод 48 хувьтай байсан байна. Харин уг судалгаанд ашигласан түүврийн аргын нөлөөлөл улсын хэмжээнд 1.7, Баруун бүсэд 1.2, Хангайн бүсэд 2.0, Төвийн бүсэд 2.5, Зүүн бүсэд 2.0, Улаанбаатар хотод 1.3 гэж тооцогдсон байна. Мөн 2009 оны статистик мэдээнээс үзэхэд 3-4 насны хүүхэд нийт хүн амын 4.4 хувийг эзэлж байсан бол өрхийн ам бүлийн дундаж тоо 4 байжээ.

Эдгээр утгуудаар тооцоход эхний байдлаар шаардлагатай түүврийн хэмжээ Баруун бүсэд 1573 өрх, Хангайн бүсэд 2742 өрх, Төвийн бүсэд 3156 өрх, Зүүн бүсэд 1839 өрх, Улаанбаатар хотод 873 өрх, улмаар улсын хэмжээнд 10183 өрх байлаа. Бүсүүдээс сонгогдох өрхийн тоо хоорондоо маш их хэлбэлзэлтэй (873-3156 өрх) байгаа учраас түүврийн алдааг бүсүүдэд ойролцоо байлгах зорилгоор түүврийн хэмжээг бүсүүдэд тэгш хуваарилах аргыг хэрэглэсэн. Ингээд нэг бүсээс сонгогдох өрхийн тоог 2100 болгож, улмаар улсын хэмжээнд нийт 10500 өрх сонгохоор болсон.

Түүврийн анхан шатны нэгж (ТАШН) бүрээс сонгогдох өрхийн тооны хувьд түүврийн зохиомж, төсвийн боломжит байдал, мэдээлэл цуглуулах нэг баг нэг ТАШН-д ажиллахад шаардагдах хугацаа зэргийг харгалзан 25 байхаар тогтоосон. Нэг бүсээс сонгогдох өрхийн тоог нэг ТАШН-ээс сонгогдох өрхийн тоонд хувааснаар бүс бүрээс 84 ТАШН, улмаар улсын хэмжээнд 420 ТАШН-ийг уг судалгаанд хамруулахаар тооцсон.

Тэгш хуваарилалтын аргаар 5 бүсэд өрхүүдийг хуваарилахдаа бүс бүрд 84 ТАШН-ийг, нийт 10500 өрхийг (84 ТАШН * 5 бүс * ТАШН тус бүрээс 25 өрх) хуваарилсан. Түүврийн бүлэглэлт буюу бүс бүрийг дотор нь хот, хөдөөгөөр бүлэглэсэн өөрөөр хэлбэл нэг бүсийн хот, хөдөөгөөс сонгогдох ТАШН-ийн тоо болон өрхийн тоог тухайн бүсийн нийт өрхийн тоонд хот, хөдөөгийн өрхийн тооны эзлэх хувийн жинд харгалзуулан тогтоосон.

Түүврийн хүрээ болон ТАШН-ийн сонголт.

2009 оны жилийн эцсийн Хүн ам, өрхийн статистик мэдээг түүврийн хүрээ болгон ашигласан ба Улаанбаатар хотын хувьд хорооны хэсгийг, аймгуудын хувьд сумын багийг ТАШН болгон тодорхойлсон. Судалгаанд хамрагдах ТАШН-ийг сонгох нь түүврийн 1-р үе шат болох юм. Энэ сонголтыг түүврийн бүлэглэлт бүрийн хувьд тус тусад нь хийдэг ба ингэхдээ жилийн эцсийн хүн ам, өрхийн тоог баг, хэсгээр гаргасан жагсаалт дээр үндэслэн системчилсэн, хэмжээнд нь пропорциональ магадлалт түүврийн аргыг ашиглан сонголт хийсэн.

Өрхийн жагсаалт болон сонголт.

Түүврийн 1-р үе шатанд сонгогдсон ТАШН тус бүрийн хувьд өрхийн жагсаалтыг шинэчлэн - сонгогдсон багийн засаг дарга, хэсгийн дарга нараас авч ҮСХ-нд ирүүлэх үүргийг аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газар хүлээсэн бөгөөд өрхийн жагсаалтыг тухайн баг, хэсгийн нутаг дэвсгэрт амьдарч буй бүх өрхийг харьяалал харгалзахгүйгээр бүртгэх зааврын дагуу бэлтгэж ирүүлсэн. Судалгаанд хамрагдах өрхүүдийг сонгох нь 2-р үе шат бөгөөд уг ажлыг ҮСХ-н дээр хийсэн. Ингэхдээ сонгогдсон баг, хэсэг буюу ТАШН бүрийн хувьд өрхүүдийг нь 1- ээс n (нийт өрхийн тоо) хүртэл дугаарлан, системчилсэн санамсаргүй магадлалт түүврийн арга ашиглан тус бүрт нь 25 өрх сонгосон.

Тус баримжуулалтын External Resources хэсэгт хавсаргасан Хүүхэд Хөгжил 2010 судалгааны түүврийн зохиомжоос тус судалгааны түүврийн зохиомжийн үндсэн элементүүд болох түүврийн үе шат болон бүлэглэлт, түүврийн хэмжээ болон түүний хуваарилалт, түүврийн хүрээ болон анхан шатны нэгжийн сонголт, өрхийн жагсаалт болон сонголт, түүврийн жингийн тооцоо зэргийн дэлгэрэнгүй тайлбарыг хавсаргасан болно.

Түүврийн хэлбэлзэл

No major deviations from the original sample design were made. All primary sampling units were accessed and successfully interviewed with good response rates.

Хамралтын түвшин

Түүвэрт сонгогдсон 10,500 өрхөөс 10,092 нь судалгаанд бүрэн хамрагдаж хамрагдалтын түвшин 98 хувьтай байна. Судалгаанд хамрагдсан өрхөд бүртгэгдсэн 15-49 насны эмэгтэйн 91 хувь, 5 хүртэлх насны хүүхдийн эх, асрамжлагчийн 96 хувь, 15-54 насны эрэгтэйн 78 хувь, 2-14 насны хүүхдийн эх, асрамжлагчийн 97 хувь нь судалгаанд бүрэн хамрагдсан байна.

Судалгаагаар 10,092 өрхөд амьдарч байгаа 35,981 хүний талаарх мэдээллийг цуглуулсан. Судалгаанд бүрэн хамрагдсан нийт өрхийн 6,086 буюу 60 хувь нь хотын, 4,006 буюу 40 хувь нь хөдөөгийн өрх байна. Нийт өрхийн тал хувь нь 3-4 ам бүлтэй, 26 хувь нь 1-2 ам бүлтэй, 24 хувь нь 5 ба түүнээс олон ам бүлтэй бөгөөд нэг өрхийн дундаж ам бүлийн тоо 3.6 байна. Нийт өрхийн 22 хувь нь эмэгтэй тэргүүлэгчтэй байна. Судалгаанд хамрагдсан 35,981 хүний хүйсийн харьцаа 96 буюу 100 эмэгтэйд 96 эрэгтэй ногдож байна. 2006 оноос хойш төрөлтийн түвшин нэмэгдсэнтэй холбоотойгоор нийт хүн амын 11 хувь нь 0-4 насны хүүхэд байна. Мөн нийт хүн амын 61 хувь нь хөдөлмөрийн насны буюу 15-59 насны эрэгтэй, 15-54 насны эмэгтэй байна.

Судалгаанд бүрэн хамрагдсан нийт эмэгтэйчүүдийг гэрлэлтийн байдлаар нь авч үзвэл 64 хувь нь гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай, 26 хувь нь огт гэрлэж эсвэл хамтран амьдарч байгаагүй, 4 хувь нь цуцалсан, 3 хувь нь бэлбэсэн, 3 хувь нь тусгаарласан хүмүүс байна. Мөн нийт эмэгтэйчүүдийн 19 хувь нь судалгааны өмнөх 2 жилд хүүхэд төрүүлжээ.

Боловсролын байдлаар нь авч үзвэл судалгаанд хамрагдсан нийт эмэгтэйчүүдийн 3 хувь нь боловсролгүй, 5 хувь нь бага, 10 хувь нь мэргэжлийн анхан шатны, 19 хувь нь суурь, 29 хувь нь бүрэн дунд, 34 хувь нь дээд боловсролтой байна. Судалгаанд 5 хүртэлх насны нийт 3,956 хүүхэд бүрэн хамрагдсанаас 50 хувь нь хөвгүүд, 50 хувь нь охид байв. 5 хүртэлх насны хүүхдийн эх, асрамжлагчдын 5 хувь нь боловсролгүй, 7 хувь нь мэргэжлийн анхан шатны, 8 хувь нь бага, 19 хувь нь суурь, 27 хувь нь бүрэн дунд, 36 хувь нь дээд боловсролтой байна.

Харин хүүхдийн амьдарч байгаа өрхийн аж байдлаар нь авч үзвэл судалгаанд хамрагдсан 5 хүртэлх насны нийт хүүхдийн 24 хувь нь доогуур, 20 хувь нь дунджаас доогуур, 19 хувь нь дундаж, 19 хувь нь дунджаас дээгүүр, үлдсэн 18 хувь нь дээгүүр түвшний аж байдалтай өрхөд амьдарч байна.

Судалгаанд бүрэн хамрагдсан нийт эрэгтэйчүүдийн 65 хувь нь гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай, 30 хувь нь огт гэрлэж эсвэл хамтран амьдарч байгаагүй, үлдсэн 5 хувь нь гэр бүлээ цуцалсан, тусгаарласан, бэлбэсэрсэн байна. Боловсролын байдлаар нь авч үзэхэд эмэгтэйчүүдийнхээс харьцангуй доогуур буюу 6 хувь нь боловсролгүй, 9 хувь нь бага, 10 хувь нь мэргэжлийн анхан шатны, 23 хувь нь дээд, 26 хувь нь бүрэн дунд, 26 хувь нь суурь боловсролтой эрэгтэйчүүд байна.

2-14 насны судалгаанд бүрэн хамрагдсан 9,131 хүүхдийн хүйсийн харьцаа нь 105, өөрөөр хэлбэл 2-14 насны 100 охидод 105 эрэгтэй ногдож байна. Судалгаанд хамрагдсан 2-14 насны хүүхдийн эхчүүдийн 4 хувь нь боловсролгүй, 8 хувь нь бага, 11 хувь нь техникийн болон мэргэжлийн, 21 хувь нь суурь, 27 хувь нь бүрэн дунд, 29 хувь нь дээд боловсролтой байв.

Түүврийн жин

Монгол Улсын “Хүүхэд хөгжил 2010” судалгааны түүврийн зохиомж нь түүврийн жин тооцсоны үндсэн дээр судалгааны үр дүнг тархаадаг, цаашдын шинжилгээ хийдэг байхаар боловсруулагдсан. Олон шатлалт бүлэглэсэн түүврийн зохиомжтой үед түүврийн нэгж буюу өрхийн сонгогдох магадлал харилцан адилгүй байдаг. ХХС 2010-д нормальчилсан жин тооцох аргыг ашигласан.

Эцсийн байдлаар, зорилтот бүлэг бүрийн хувьд нормальчлагдсан түүврийн жин нь дараах утгуудын хооронд (нийт 420 ТАШН-ийн хувьд) хэлбэлзэж байхаар тооцоологдсон ба эдгээр нь судалгааны анхан шатны мэдээллийн файлд нэгтгэгдэж, үр дүнгийн үзүүлэлтүүдийг жигнэгдсэн байдлаар тооцоход ашиглагдсан.

- Өрх - 0.145-3.876

- 15-49 насны эмэгтэйчүүд - 0.138-3.794

- 5 хүртэлх насны хүүхдүүд - 0.142-4.042
- 15-54 насны эрэгтэйчүүд - 0.139-3.712
- 2-14 насны хүүхдүүд - 0.149-4.238

Жингийн тооцооллын тухай дэлгэрэнгүй мэдээллийг External Resources хэсэгт хавсаргасан Хүүхэд Хөгжил 2010 судалгааны түүврийн зохиомжоос мэдэх боломжтой.

Асуулгууд

Тойм

Судалгааны асуулгыг боловсруулахдаа судалгааны зорилго, хамрах хүрээг харгалзан НҮБХС-гаас зөвлөмж болгосон стандарт 3 асуулгыг суурь болгон ашигласан бөгөөд шаардлагатай үед өөрийн орны онцлогыг тусгасан. Мөн асуулга, түүнд орох асуулт, үзүүлэлтийг боловсруулахдаа өмнөх судалгаатай болон олон улсын түвшинд харьцуулагдах шинж чанарыг алдагдуулахгүй байх зарчмыг баримталсан. Өнөөгийн хэрэгцээ шаардлагыг үндэслэн энэ удаагийн судалгаанд 15-54 насны эрэгтэйн болон 2-14 насны хүүхдийн асуулгыг шинээр боловсруулж нэмсэн нь өмнөх судалгаанаас онцлог юм. Ингээд дараах 5 төрлийн асуулгаар энэ удаагийн судалгааны мэдээллийг цуглуулсан.

Үүнд:

1. Өрхийн асуулга
2. 15-49 насны эмэгтэйн асуулга
3. 5 хүртэлх насны хүүхдийн асуулга
4. 15-54 насны эрэгтэйн асуулга
5. 2-14 насны хүүхдийн асуулга

Асуулгын хуудасны асуултын ойлгомжтой байдал, асуулт хоорондын уялдаа холбоо, багийн бүрэлдэхүүн, зохион байгуулалт, түүвэрлэлт, нэг өрхөөс судалгаа авахад зарцуулах дундаж хугацааг тодорхойлох, мэдээллийг компьютерт оруулах програмыг турших зорилгоор туршилтын судалгааг Улаанбаатар хотын Хан-Уул, Чингэлтэй дүүрэг болон Хэнтий аймгийн Хэрлэн, Дадал суманд 2010 оны 5-р сард зохион байгуулж явуулсан. Туршилтын судалгааны үр дүнд тулгуурлан асуулгын хуудсанд үг найруулгын засварыг хийж, асуулт хоорондын уялдааг сайжруулан боловсруулсан.

Тус баримжуулалтын External Resources хэсэгт Хүүхэд хөгжил 2010 судалгааны асуулгын хуудсуудын эх хувилбарыг хавсаргасан болно.

Мэдээлэл цуглуулалт

Мэдээлэл цуглуулалтын огноо

Эхлэх	Дуусах	Цикл
2010-08-27	2010-12-20	1

Мэдээлэл цуглуулалтын бодлого

Face-to-face [f2f]

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТЫН ТЭМДЭГЛЭГЭЭ

Мэдээлэл цуглуулах ажилтнуудад зориулсан сургалтыг 2010 оны 8 сарын 4-18-ны хооронд 15 хоногийн хугацаанд танхимын болон дадлагын гэсэн 2 хэлбэрээр зохион байгуулсан. Сургалтын хугацаанд асуулгын бүлэг тус бүрээр холбогдох мэргэжлийн хүмүүсээр хичээл заалгаж, дадлага хийлгэн эцэст нь сургалтад оролцогчдоос шалгалт авч судалгааны мэдээлэл цуглуулах ажилтнуудыг сонгон шалгаруулав. Судалгааны мэдээллийг цуглуулах үүрэг бүхий 10 багийг тус бүр 1 ахлагч, 1 хянагч, 5 ярилцлага авагч (3 эмэгтэй, 2 эрэгтэй) нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй байхаар зохион байгуулж ажиллуулсан. Баг бүрийн эрэгтэй ярилцлага авагч нар хэмжигчийн үүргийг давхар гүйцэтгэж ажилласан.

Мэдээллийг цуглуулахдаа түүврийн анхан шатны нэгж болох баг, хэсгийн газар зүйн байршлыг тэмдэглэн авч мэдээллийн сан бүрдүүлснээр Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын мэдээллийн сантай уялдуулж, хүүхэд, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн нийгэм, эрүүл мэнд, боловсролын үзүүлэлтүүдээр газрын зураглал боловсруулах боломж нээгдэж байна.

Мэдээлэл цуглуулалт

Нэр	Товчлол	Харьяалал
Үндэсний Статистикийн хороо	ҮСХ	Монгол Улсын Их хурал

SUPERVISION

Судалгааны мэдээлэл цуглуулалтын ажлыг 2010 оны 8-р сарын 27-ноос эхлэн 12-р сарын 20-нд дуусгасан ба мэдээлэл цуглуулалтын явц, чанарт ҮСХ, НҮБХС-гийн мэргэжилтнүүд, олон улсын зөвлөх, судалгааны Удирдлагын зөвлөлийн гишүүд хяналт тавьж ажилласан. Хяналтын явцад гарсан алдаа дутагдал, ололт амжилтыг тухай бүр танилцуулж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллаж байсныг дурдах нь зүйтэй.

Мэдээлэл боловсруулалт

Мэдээлэл засалт

Түүвэрт сонгогдсон өрхүүдээс цуглуулсан мэдээллийг өөрийн орны асуулгын хуудсанд нийцүүлэн боловсруулсан мэдээлэл шивэлтийн програм (CSPro 4.0)-ыг ашиглан компьютерт оруулсан бөгөөд үүнийг 10 ажилтан 2010 оны 10-12 сарын хооронд хийж гүйцэтгэсэн. Мэдээллийн чанарыг баталгаажуулахын тулд бүх мэдээллийг давтан шивж, үзүүлэлт хоорондын уялдааг шалгаж холбогдох засварыг хийж мэдээллийн санг эцэслэн боловсруулсан.

Бусад боловсруулалт

Мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ НҮБХС-гийн Удирдах байгууллагын мэргэжилтнүүдийн боловсруулсан стандарт томъёолол болон үр дүнгийн хүснэгтийн загварыг өөрийн орны асуулгын хуудсанд нийцүүлэн өөрчлөхийн зэрэгцээ нэмэлт хүснэгтүүдийг SPSS 18.0 програм ашиглан боловсруулсан.

Мэдээллийн үнэлэлт

No content available

Файлын тайлбар

variable_list

Household

Агуулга	Энэхүү файл нь Хүүхэд хөгжил 2010 судалгааны Үндэсний статистикийн хорооны даргын 2010 оны 01/87 тоот тушаалаар батлагдсан маягт ХХС4-1-ийн "ӨРХИЙН АСУУЛГА"-ын өрхийн мэдээллийн(НН1-НН19), ус болон ариун цэврийн байгууламжийн мэдээллийн(WS1-WS11), өрхийн зарим нэмэлт мэдээллийн(НС1С-НС15), 2-14 настай хүүхдийн хүмүүжлийн мэдээллийн(CD6-CD22), гар угаах газрын мэдээллийн(HW1-HW5_Y), иоджуулсан давсны хэрэглээний мэдээллийн(SI1-SI5) хэсгүүд болон өрхийн тэргүүлэгчийн хүйс,боловсрол,яс үндэс, шашин шүтлэг зэрэг мэдээллийг агуулсан.Тус файл нь 135 хувьсагчтай.				
Тохиолдолууд	10500				
Хувьсагч	135				
Бүтэц	Төрөл: relational Түлхүүрүүд: НН1(Түүвэрлэгдсэн нэгжийн дугаар), НН2(Өрхийн дугаар)				
Хувилбар	-v1.1				
Гүйцэтгэгч	Үндэсний Статистикийн Хороо.				
Missing Data	A standard coding system and formatting has been used throughout the questionnaires. For example, the codes 9, 99, 999 and 9999 are used for "NA" responses as well as missing and the codes 8, 98, 998 and 9998 are used for "DK" responses but are not used for missing if the measure of the variables are not scale . The codes 6, 96, 996 and 9996 are reserved for "Other" responses.				

Хувьсагчид

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V1	НН1	Түүвэрлэгдсэн нэгжийн дугаар	discrete	numeric	
V2	НН2	Өрхийн дугаар	discrete	numeric	
V3	НН3	Ярилцлага авагчийн нэр, дугаар	discrete	numeric	
V4	НН4	Багийн ахлагчийн нэр, дугаар	discrete	numeric	
V5	НН5_Y	Ярилцлага авсан он	discrete	numeric	
V6	НН5_M	Ярилцлага авсан сар	discrete	numeric	
V7	НН5_D	Ярилцлага авсан өдөр	discrete	numeric	
V8	НН6	Байршил	discrete	numeric	
V9	НН7A	Аймаг/ нийслэлийн нэр, код	discrete	numeric	
V10	НН7B	Сум/ дүүргийн нэр, код	contin	numeric	
V11	НН7C	Баг/ хорооны нэр, код	contin	numeric	
V12	НН7D	Хэсгийн нэр, код	discrete	numeric	
V13	НН9	Ярилцлагын үр дүн	discrete	numeric	
V14	НН10	Ярилцлага өгөгчийн нэр, мөрийн дугаар	discrete	numeric	
V15	НН11	Ам бүлийн тоо	contin	numeric	
V16	НН12	Өрхийн 15-49 насны эмэгтэйчүүдийн тоо	contin	numeric	
V17	НН13	Судалгаанд бүрэн хамрагдсан 15-49 насны эмэгтэйчүүдийн тоо	contin	numeric	
V18	НН14	Өрхийн 5 хүртэлх насны хүүхдийн тоо	contin	numeric	
V19	НН15	Судалгаанд бүрэн хамрагдсан 5 хүртэлх насны хүүхдийн тоо	contin	numeric	

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V20	HH15A	Өрхийн 15-54 насны эрэгтэйчүүдийн тоо	contin	numeric	
V21	HH15B	Судалгаанд бүрэн хамрагдсан 15-54 насны эрэгтэйчүүдийн тоо	contin	numeric	
V22	HH15C	Өрхийн 2-14 насны хүүхдийн тоо	contin	numeric	
V23	HH15D	Судалгаанд бүрэн хамрагдсан 2-14 насны хүүхдийн тоо	contin	numeric	
V24	HH16	Хянагчийн нэр, дугаар	discrete	numeric	
V25	HH17	Шивэлтийн операторын нэр, дугаар	discrete	numeric	
V26	HH18_H	Ярилцлага эхэлсэн цаг	discrete	numeric	
V27	HH18_M	Ярилцлага эхэлсэн минут	discrete	numeric	
V28	HH19_H	Ярилцлага дууссан цаг	discrete	numeric	
V29	HH19_M	Ярилцлага дууссан минут	discrete	numeric	
V30	WS1	Ундны усны эх үүсвэр	discrete	numeric	Танайх ундны усаа голдуу ямар эх үүсвэрээс авдаг вэ?
V31	WS2	Ахуйн хэрэглээний усны эх үүсвэр	discrete	numeric	Танайх ахуйн хэрэглээний усаа голдуу ямар эх үүсвэрээс авдаг вэ?
V32	WS3	Усны эх үүсвэрийн байрлал	discrete	numeric	Усны тэр эх үүсвэр чинь хаана байдаг вэ?
V33	WS4	Усаа авахад зарцуулдаг дундаж хугацаа	discrete	numeric	Усаа авахдаа дунджаар хэдэн минут зарцуулдаг вэ?
V34	WS5	Өрхийн хэрэглээний усаа голчлон авдаг хүн	discrete	numeric	Усаа голдуу хэн авдаг вэ?
V35	WS6	Ундны усны аюулгүй байдлыг хангах зорилгоор арга хэмжээ авдаг эсэх	discrete	numeric	Танайх усаа уухдаа аюулгүй байдлыг нь хангах үүднээс ямар нэг арга хэрэглэдэг үү?
V36	WS7_A	Ундны усны аюулгүй байдлыг хангах зорилгоор авдаг арга хэмжээ- Буцалгах	discrete	character	Танайх усаа уухдаа аюулгүй байдлыг нь хангах үүднээс ямар арга хэрэглэдэг вэ? - Буцалгах
V37	WS7_B	Ундны усны аюулгүй байдлыг хангах зорилгоор авдаг арга хэмжээ- Ариутгалын бодис хийх	discrete	character	Танайх усаа уухдаа аюулгүй байдлыг нь хангах үүднээс ямар арга хэрэглэдэг вэ?- Ариутгалын бодис хийх
V38	WS7_C	Ундны усны аюулгүй байдлыг хангах зорилгоор авдаг арга хэмжээ - Даавуу, марлиар шүүх	discrete	character	Танайх усаа уухдаа аюулгүй байдлыг нь хангах үүднээс ямар арга хэрэглэдэг вэ?- Даавуу, марлиар шүүх
V39	WS7_D	Ундны усны аюулгүй байдлыг хангах зорилгоор авдаг арга хэмжээ - Ус цэвэршүүлэгч хэрэглэх	discrete	character	Танайх усаа уухдаа аюулгүй байдлыг нь хангах үүднээс ямар арга хэрэглэдэг вэ?- Ус цэвэршүүлэгч хэрэглэх
V40	WS7_E	Ундны усны аюулгүй байдлыг хангах зорилгоор авдаг арга хэмжээ - Нарны гэрлээр халдваргүйжүүлэх	discrete	character	Танайх усаа уухдаа аюулгүй байдлыг нь хангах үүднээс ямар арга хэрэглэдэг вэ?- Нарны гэрлээр халдваргүйжүүлэх
V41	WS7_F	Ундны усны аюулгүй байдлыг хангах зорилгоор авдаг арга хэмжээ - Тунгаах	discrete	character	Танайх усаа уухдаа аюулгүй байдлыг нь хангах үүднээс ямар арга хэрэглэдэг вэ? - Тунгаах
V42	WS7_X	Ундны усны аюулгүй байдлыг хангах зорилгоор авдаг арга хэмжээ - Бусад	discrete	character	Танайх усаа уухдаа аюулгүй байдлыг нь хангах үүднээс ямар арга хэрэглэдэг вэ? - Бусад(тодруулах)
V43	WS7_Z	Ундны усны аюулгүй байдлыг хангах зорилгоор авдаг арга хэмжээ - Мэдэхгүй	discrete	character	Танайх усаа уухдаа аюулгүй байдлыг нь хангах үүднээс ямар арга хэрэглэдэг вэ?- Мэдэхгүй
V44	WS7A	Унд болон ахуйн хэрэглээндээ хоногт дунджаар хэрэглэдэг усны хэмжээ, литр	discrete	numeric	Танайх унд болон ахуйн хэрэглээндээ хоногт дунджаар хэдэн литр ус хэрэглэдэг вэ?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V45	WS8	Танай өрхийн ашигладаг жорлон	discrete	numeric	Танайх ямар жорлон ашигладаг вэ?
V46	WS9	Жорлонгоо бусадтай хамтарч ашигладаг эсэх	discrete	numeric	Танайх жорлонгоо бусадтай хамтарч ашигладаг уу?
V47	WS10	Жорлонгоо танил өрхүүдтэй хамтарч ашигладаг эсвэл энэ жорлон нийтийн жорлон эсэх	discrete	numeric	Танайх жорлонгоо танил өрхүүдтэй хамтарч ашигладаг уу эсвэл энэ жорлон нийтийн жорлон уу?
V48	WS11	Нийт хэдэн өрх энэ жорлонг хамтарч ашигладаг тухай	discrete	numeric	Танай өрхийг оролцуулаад нийт хэдэн өрх энэ жорлонг хамтарч ашигладаг вэ?
V49	HC1C	Өрхийн тэргүүлэгчийн яс үндэс	discrete	numeric	Та өрхийн тэргүүлэгчийнхээ яс үндсийг хэлнэ үү?
V50	HC1A	Өрхийн тэргүүлэгч шүтдэг шашин	discrete	numeric	Танай өрхийн тэргүүлэгч шашин шүтдэг үү?
V51	HC1D	Тухайн өрхийн сууцны төрөл	discrete	numeric	
V52	HC1E	Өрхийн сууцны талбайн хэмжээ	discrete	numeric	Танай сууцны талбайн хэмжээ хэд вэ?
V53	HC1F	Сууцны өрөөний тоо	discrete	numeric	Танай сууц нийт хэдэн өрөөтэй вэ?
V54	HC2	Сууцны унтлагын өрөө	discrete	numeric	Танай сууц унтлагын хэдэн өрөөтэй вэ?
V55	HC2A	Гэрийн ханын тоо	discrete	numeric	Танай гэр хэдэн ханатай вэ?
V56	HC3	Сууцны шалны үндсэн материал	discrete	numeric	Танай сууцны шалны үндсэн материал юу вэ?
V57	HC4	Сууцны дээврийн үндсэн материал	discrete	numeric	Танай сууцны дээврийн үндсэн материал юу вэ?
V58	HC5	Сууцны ханын үндсэн материал	discrete	numeric	Танай сууцны ханын үндсэн материал юу вэ?
V59	HC5A	Сууцны халаалтын эх үүсвэр	discrete	numeric	Танай сууцны халаалтын эх үүсвэр юу вэ?
V60	HC5B	Халаалтандаа голчлон хэрэглэгдэг түлшний төрөл	discrete	numeric	Танайх халаалтандаа голдуу ямар түлш хэрэглэдэг вэ?
V61	HC6	Хоолоо болгохдоо голдуу хэрэглэдэг түлш	discrete	numeric	Танайх хоолоо болгохдоо голдуу ямар түлш хэрэглэдэг вэ?
V62	HC7	Хоолоо хийдэг газар	discrete	numeric	Танайх хоолоо голдуу хаана хийдэг вэ?
V63	HC8_A	[A] Цахилгаан эрчим хүчтэй эсэх	discrete	numeric	Танайд цахилгаан эрчим хүчтэй юу?
V64	HC8_F	[F] Нар, салхины эрчим хүчний үүсгүүртэй эсэх	discrete	numeric	Танайд нар, салхины эрчим хүчний үүсгүүр бий юу?
V65	HC8_G	[G] Компьютертэй эсэх	discrete	numeric	Танайд компьютер бий юу?
V66	HC8_H	[H] Интернэтийн холболттой эсэх	discrete	numeric	Танайд интернэтийн холболт бий юу?
V67	HC8_C	[C] Телевизортой эсэх	discrete	numeric	Танайд телевизор бий юу?
V68	HC8_B	[B] Радио хүлээн авагчтай эсэх	discrete	numeric	Танайд радио хүлээн авагч бий юу?
V69	HC8_D	[D] Суурин телефон утастай эсэх	discrete	numeric	Танайд суурин телефон утас бий юу?
V70	HC8_E	[E] Хөргөгчтэй эсэх	discrete	numeric	Танайд хөргөгч бий юу?
V71	HC8_J	[J] Угаалгын машинтай эсэх	discrete	numeric	Танайд угаалгын машин бий юу?
V72	HC8_K	[K] Тоос сорогчтой эсэх	discrete	numeric	Танайд тоос сорогч бий юу?
V73	HC8_L	[L] Номын сантай эсэх	discrete	numeric	Танайх номын сантай бий юу?
V74	HC9_A	[A] Бугуйн цагтай эсэх	discrete	numeric	Танай өрхийн хэн нэг гишүүнд бугуйн цаг бий юу?
V75	HC9_B	[B] Гар утастай эсэх	discrete	numeric	Танай өрхийн хэн нэг гишүүнд гар утас бий юу?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V76	HC9_G	[G] Видео камер, зургийн аппараттай эсэх	discrete	numeric	Танай өрхийн хэн нэг гишүүнд видео камер, зургийн аппарат бий юу?
V77	HC9_C	[C] Унадаг дугуйтай эсэх	discrete	numeric	Танай өрхийн хэн нэг гишүүнд унадаг дугуй бий юу?
V78	HC9_D	[D] Мотоциклтой эсэх	discrete	numeric	Танай өрхийн хэн нэг гишүүнд мотоцикл бий юу?
V79	HC9_E	[E] Ердийн хөсөгтэй эсэх	discrete	numeric	Танай өрхийн хэн нэг гишүүнд ердийн хөсөг бий юу?
V80	HC9_F	[F] Автомашинтай эсэх	discrete	numeric	Танай өрхийн хэн нэг гишүүнд автомашин бий юу?
V81	HC9_H	[H] Трактортай эсэх	discrete	numeric	Танай өрхийн хэн нэг гишүүнд трактор бий юу?
V82	HC10	Сууцны өмчлөл	discrete	numeric	Энэ сууц танай өөрийн өмч үү?
V83	HC11	Тариалангийн талбайтай эсэх	discrete	numeric	Танайх тариалангийн талбайтай юу?
V84	HC12_U	Тариалангийн талбайн хэмжээ-нэгж	discrete	numeric	Танай тариалангийн талбайн газрын хэмжих нэгж юу вэ?
V85	HC12_N	Тариалангийн талбайн хэмжээ-хэмжээ	discrete	numeric	Танай тариалангийн талбайн хэмжээ хэд вэ?
V86	HC13	Хувийн мал, тэжээвэр амьтантай эсэх	discrete	numeric	Танайх хувийн мал, тэжээвэр амьтантай юу?
V87	HC14_A	Мал, тэжээвэр амьтаны тоо [A] Үхэр	discrete	numeric	Танайх хэдэн үхэртэй вэ?
V88	HC14_B	Мал, тэжээвэр амьтаны тоо [B] Адуу	discrete	numeric	Танайх хэдэн адуутай вэ?
V89	HC14_C	Мал, тэжээвэр амьтаны тоо [C] Ямаа	discrete	numeric	Танайх хэдэн ямаатай вэ?
V90	HC14_D	Мал, тэжээвэр амьтаны тоо [D] Хонь	discrete	numeric	Танайх хэдэн хоньтой вэ?
V91	HC14_H	Мал, тэжээвэр амьтаны тоо [H] Тэмээ	discrete	numeric	Танайх хэдэн тэмээтэй вэ?
V92	HC14_E	Мал, тэжээвэр амьтаны тоо [E] Тахиа	discrete	numeric	Танайх хэдэн тахиятай вэ?
V93	HC14_F	Мал, тэжээвэр амьтаны тоо [F] Гахай	discrete	numeric	Танайх хэдэн гахайтай вэ?
V94	HC14_X	Мал, тэжээвэр амьтаны тоо [X] Бусад (тодруулах)	discrete	numeric	Танайх хэдэн төрлийн бусад(тодруулах)тэжээвэр амьтантай вэ?
V95	HC15	өрхийн хэн нэг гишүүн банкинд хадгаламжийн, картын эсвэл харилцах данстай эсэх	discrete	numeric	Танай өрхийн хэн нэг гишүүн банкинд хадгаламжийн, картын эсвэл харилцах данстай юу?
V96	CD6	Өрхийн 2-14 насны хүүхдийн тоо	discrete	numeric	
V97	CD8	Санамсаргүйгээр сонгогдсон хүүхдийн дугаар (CD1-ээс)	discrete	numeric	
V98	CD9	Сонгогдсон хүүхдийн дугаарт харгалзах (CD8) нэр, мөрийн дугаар	discrete	numeric	
V99	CD_FLAG	Санамсаргүйгээр сонгогдсон хүүхдийн мөрийн дугаар зөв эсэх	discrete	numeric	Санамсаргүйгээр сонгогдсон хүүхдийн мөрийн дугаар зөв үү?
V100	CD11	Дуртай зүйлээ хийх, гэрээс гарахыг хорьсон эсэх	discrete	numeric	(Нэр)-ийн дуртай зүйлээ хийх, гэрээс гарахыг хорьсон уу?
V101	CD12	Гаргасан зан ааш нь яагаад буруу гэдгийг тайлбарлаж хэлсэн эсэх	discrete	numeric	(Нэр)-ийн гаргасан зан ааш нь яагаад буруу гэдгийг тайлбарлаж хэлсэн үү?
V102	CD13	Дугтчиж, сэгсэрсэн эсэх	discrete	numeric	(Нэр)-ийг дугтчиж, сэгсэрсэн үү?
V103	CD14	Орилж, хашгирч, чарласан эсэх	discrete	numeric	Нэр) рүү орилж, хашгирч, чарласан уу?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V104	CD15	Шийтгэх зорилгоор ямар нэг ажил хийлгэхээр өгсөн эсэх	discrete	numeric	(Нэр)-ийг шийтгэх зорилгоор ямар нэг ажил хийлгэхээр өгсөн үү?
V105	CD16	Нүцгэн гараар бөгсөн дээр нь алгадаж, цохиж, зодсон эсэх	discrete	numeric	(Нэр)-ийг нүцгэн гараар бөгсөн дээр нь алгадаж, цохиж, зодсон уу?
V106	CD17	Бөгс эсвэл биеийн аль нэг хэсгийг бүс, саваа гэх мэт хатуу биет зүйлээр цохьсон эсэх	discrete	numeric	(Нэр)-ийн бөгс эсвэл биеийн аль нэг хэсгийг бүс, саваа гэх мэт хатуу биет зүйлээр цохьсон уу?
V107	CD18	Тэнэг, залхуу гэх мэтээр дуудсан эсэх	discrete	numeric	(Нэр)-ийг тэнэг, залхуу гэх мэтээр дуудсан уу?
V108	CD19	Нүүр, толгой, чихийг алгадаж, цохьсон эсэх	discrete	numeric	(Нэр)-ийн нүүр, толгой, чихийг алгадаж, цохьсон уу?
V109	CD20	Гар, тохой, хөлийг алгадаж, цохьсон эсэх	discrete	numeric	(Нэр)-ийн гар, тохой, хөлийг алгадаж, цохьсон уу?
V110	CD21	Маш хүчтэйгээр олон удаа цохиж, зодсон эсэх	discrete	numeric	(Нэр)-ийг маш хүчтэйгээр олон удаа цохиж, зодсон уу?
V111	CD22	Хүүхдийг өсгөж, хүмүүжүүлэхдээ түүнд бие махбодийн шийтгэл оногдуулах нь зүйтэй гэж үздэг эсэх	discrete	numeric	Та хүүхдийг өсгөж, хүмүүжүүлэхдээ түүнд бие махбодийн шийтгэл оногдуулах нь зүйтэй гэж үздэг үү?
V112	HW1	Өрхийн гишүүд гараа угаадаг газар	discrete	numeric	Та надад танай өрхийн гишүүд гараа угаадаг газрыг үзүүлнэ үү?
V113	HW2	Гар угаах газарт ус байгаа эсэхийг ажиглах	discrete	numeric	
V114	HW3_A	Гар угаах газарт ямар нэг төрлийн саван байгаа эсэх- Шахмал саван	discrete	character	
V115	HW3_C	Гар угаах газарт ямар нэг төрлийн саван байгаа эсэх- Шингэн саван	discrete	character	
V116	HW3_X	Гар угаах газарт ямар нэг төрлийн саван байгаа эсэх- Бусад	discrete	character	
V117	HW3_Y	Гар угаах газарт ямар нэг төрлийн саван байгаа эсэх- Байхгүй	discrete	character	Гар угаах газарт ямар нэг төрлийн саван байгаа юу ?
V118	HW4	Гараа угаахдаа хэрэглэдэг ямар нэг төрлийн саван байгаа эсэх	discrete	numeric	Танайд гараа угаахдаа хэрэглэдэг ямар нэг төрлийн саван байгаа юу?
V119	HW5_A	Шахмал савангаа үзүүлэх А	discrete	character	Та надад шахмал савангаа үзүүлнэ үү?
V120	HW5_C	Шингэн савангаа үзүүлэх С	discrete	character	Та надад шингэн савангаа үзүүлнэ үү?
V121	HW5_X	Бусад савангаа үзүүлэх Х	discrete	character	Та надад бусад савангаа үзүүлнэ үү?
V122	HW5_Y	Байхгүй Y	discrete	character	Та надад савангаа үзүүлнэ үү?
V123	SI1	надад хоолондоо хэрэглэдэг давснаасаа бага зэргийг өгнө үү	discrete	numeric	Та надад хоолондоо хэрэглэдэг давснаасаа бага зэргийг өгнө үү?
V124	SI1A	Давс хаанахыг нь асуух	discrete	numeric	Энэ хаанахын давс вэ?
V125	SI1B	Ямар төрлийн давс эсэх	discrete	numeric	Энэ ямар төрлийн давс вэ?
V126	SI1C	Давсны үйлдвэрийн нэр	discrete	numeric	
V127	HHSEX	Өрхийн тэргүүлэгчийн хүйс	discrete	numeric	
V128	region	Бүс нутаг	discrete	numeric	
V129	area	Хот хөдөө	discrete	numeric	
V130	ethnicity	Өрхийн тэргүүлэгчийн яс үндэс	discrete	numeric	
V131	religion	Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг	discrete	numeric	
V132	helevel	Өрхийн тэргүүлэгчийн боловсрол	discrete	numeric	

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V133	hhweight	Өрхийн түүврийн жин	contin	numeric	
V134	wscore	Аж байдлын түвшний оноо	contin	numeric	
V135	windex5	Аж байдлын түвшин	discrete	numeric	

Household Roster

Агуулга	Энэхүү файл нь Хүүхэд хөгжил 2010 судалгааны Үндэсний статистикийн хорооны даргын 2010 оны 01/87 тоот тушаалаар батлагдсан маягт ХХС4-1-ийн "ӨРХИЙН АСУУЛГА"-ын өрхийн хаягийн мэдээллийн(НН1-НН7d), өрхийн гишүүдийн ерөнхий мэдээллийн(HL1-HL14), өрхийн 5 -аас дээш насны гишүүдийн боловсролын тухай мэдээллийн(ED1-ED8b), 5-17 настай хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн(CL1-CL10)хэсгүүд болон өрхийн тэргүүлэгчийн хүйс,боловсрол,яс үндэс, шашин шүтлэг, хүн ам зүйн ачаалал ба аж байдлын түвшин тооцох тооцооны нэмэлт үзүүлэлтүүдийн мэдээллийг агуулсан. Тус файл нь 67 хувьсагчтай.
Тохиолдолууд	35747
Хувьсагч	67
Бүтэц	Төрөл: relational Түлхүүрүүд: НН1(Түүвэрлэгдсэн нэгжийн дугаар), НН2(Өрхийн дугаар), HL1(Мөрийн дугаар)
Хувилбар	-v1.1
Гүйцэтгэгч	Үндэсний Статистикийн Хороо
Missing Data	A standard coding system and formatting has been used throughout the questionnaires. For example, the codes 9, 99, 999 and 9999 are used for "NA" responses as well as missing and the codes 8, 98, 998 and 9998 are used for "DK" responses but are not used for missing if the measure of the variables are not scale . The codes 6, 96, 996 and 9996 are reserved for "Other" responses.

Хувьсагчид

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V136	НН1	Түүвэрлэгдсэн нэгжийн дугаар	contin	numeric	
V137	НН2	Өрхийн дугаар	contin	numeric	
V138	HL1	Мөрийн дугаар	discrete	numeric	Өрхийн бүх гишүүдийн нэрийг өрхийн тэргүүлэгчээс эхлэн хэлнэ үү?
V139	HL3	Өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай	discrete	numeric	(Нэр) өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай вэ?
V140	HL4	Хүйс	discrete	numeric	(Нэр) эрэгтэй юу, эмэгтэй юу?
V141	HL5_Y	Төрсөн он	discrete	numeric	(Нэр)-ийн төрсөн оныг хэлнэ үү?
V142	HL5_M	Төрсөн сар	discrete	numeric	(Нэр)-ийн төрсөн сарыг хэлнэ үү?
V143	HL5_D	Төрсөн өдөр	discrete	numeric	(Нэр)-ийн төрсөн өдрийг хэлнэ үү?
V144	HL6	Нас	discrete	numeric	(Нэр) хэдэн настай вэ?
V145	HL7	15-49 насны эмэгтэйчүүдийн мөрийн дугаар	discrete	numeric	
V146	HL7A	15-54 насны эрэгтэйчүүдийн мөрийн дугаар	discrete	numeric	
V147	HL8	5-17 насны хүүхдийн хувьд эх/асрамжлагчийн мөрийн дугаар	discrete	numeric	(Нэр)-ийн эх/асрамжлагч нь хэн бэ?
V148	HL9	5 хүртэлх насны хүүхдийн хувьд эх/асрамжлагчийн мөрийн дугаар	discrete	numeric	(Нэр)-ийн эх/асрамжлагч нь хэн бэ?
V149	HL11	Төрсөн эх нь амьд сэрүүн эсэх	discrete	numeric	(Нэр)-ийн төрсөн эх нь амьд сэрүүн байгаа юу?
V150	HL12	Төрсөн эх нь хамт амьдарч байгаа эсэх	discrete	numeric	(Нэр)-ийн төрсөн эх нь хамт амьдарч байгаа юу?
V151	HL13	Төрсөн эцэг нь амьд сэрүүн эсэх	discrete	numeric	(Нэр)-ийн төрсөн эцэг нь амьд сэрүүн байгаа юу?
V152	HL14	Төрсөн эцэг нь хамт амьдарч байгаа эсэх	discrete	numeric	(Нэр)-ийн төрсөн эцэг нь хамт амьдарч байгаа юу?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V153	ED1	5 ба түүнээс дээш насны гишүүдийн хувьд мөрийн дугаар	discrete	numeric	
V154	ED3	Цэцэрлэг сургуульд хүмүүжиж байсан эсэх	discrete	numeric	(Нэр) цэцэрлэгт хүмүүжиж/сургуульд сурч байсан уу?
V155	ED4_A	Төгссөн сургуулийн хамгийн дээд талын шатлал	discrete	numeric	(Нэр) хамгийн дээд тал нь аль шатны сургуулийг төгссөн бэ?
V156	ED4_B	Төгссөн сургуулийн хамгийн дээд талын анги/ курс	discrete	numeric	(Нэр) хамгийн дээд тал нь хэддүгээр анги/ курсыг төгссөн бэ?
V157	ED5	2010/2011 оны энэ хичээлийн жилд цэцэрлэгт хүмүүжиж/сургуульд сурч байгаа эсэх	discrete	numeric	(Нэр)2010/2011 оны энэ хичээлийн жилд цэцэрлэгт хүмүүжиж/сургуульд сурч байгаа юу?
V158	ED6_A	2010/2011 оны энэ хичээлийн жилд аль шатны сургуульд сурч байгаа?	discrete	numeric	(Нэр) 2010/2011 оны энэ хичээлийн жилд аль шатны сургуульд сурч байгаа вэ?
V159	ED6_B	2010/2011 оны энэ хичээлийн жилд хэддүгээр анги/ курст сурч байгаа	discrete	numeric	(Нэр) 2010/2011 оны энэ хичээлийн жилд хэддүгээр анги/ курст сурч байгаа вэ?
V160	ED7	2009/2010 оны өмнөх хичээлийн жилд цэцэрлэгт хүмүүжиж/сургуульд сурсан эсэх	discrete	numeric	(Нэр)2009/2010 оны өмнөх хичээлийн жилд цэцэрлэгт хүмүүжиж/сургуульд сурсан уу?
V161	ED8_A	2009/2010 оны өмнөх хичээлийн жилд аль шатны сургуульд сурсан эсэх	discrete	numeric	(Нэр) 2009/2010 оны өмнөх хичээлийн жилд аль шатны сургуульд сурсан бэ?
V162	ED8_B	2009/2010 оны өмнөх хичээлийн жилд хэддүгээр анги/ курст сурсан эсэх	discrete	numeric	(Нэр) 2009/2010 оны өмнөх хичээлийн жилд хэддүгээр анги/ курст сурсан бэ?
V163	CL1	5-17 настай хүүхдийн мөрийн дугаар	discrete	numeric	
V164	CL3	Сүүлийн 7 хоногт өрхөөсөө гадуур ямар нэг ажил хийсэн эсэх	discrete	numeric	(Нэр) сүүлийн 7 хоногт өрхөөсөө гадуур ямар нэг ажил хийсэн үү?
V165	CL4	Сүүлийн 7 хоногт тухайн ажилд зарцуулсан нийт цаг	discrete	numeric	(Нэр) сүүлийн 7 хоногт тухайн ажилд нийт хэдэн цаг зарцуулсан бэ?
V166	CL7	Сүүлийн 7 хоногт өөрийн өрхийн аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулж ямар нэг ажил хийсэн эсэх	discrete	numeric	(Нэр) сүүлийн 7 хоногт өөрийн өрхийн аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулж ямар нэг ажил хийсэн үү?
V167	CL8	Сүүлийн 7 хоногт өөрийн өрхийн аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулсан ажилд зарцуулсан нийт цаг	discrete	numeric	(Нэр)сүүлийн 7 хоногт тухайн ажилд нийт хэдэн цаг зарцуулсан бэ?
V168	CL8A	Сүүлийн 7 хоногт ямар нэг ажил хийгээгүй боловч ер нь тогтмол ажилтай эсэх	discrete	numeric	(Нэр) сүүлийн 7 хоногт ямар нэг ажил хийгээгүй боловч ер нь тогтмол ажилтай юу?
V169	CL8B	7 хоногт дунджаар хэдэн цаг ажилладаг тухай	discrete	numeric	(Нэр) 7 хоногт дунджаар хэдэн цаг ажилладаг вэ?
V170	CL8C	Сүүлийн 7 хоног эрхэлсэн үндсэн ажлын мэргэжил	contin	numeric	Хэрэв сүүлийн 7 хоногт ямар нэг ажил хийсэн бол: (Нэр) сүүлийн 7 хоногт ямар мэргэжлийн үндсэн ажил эрхэлсэн бэ? Хэрэв ер нь тогтмол ажилтай бол: (Нэр) ямар мэргэжлийн үндсэн ажил эрхэлдэг вэ?
V171	CL8D	Хөдөлмөр эрхлэлтийн статус	discrete	numeric	(Нэр)-ийн хөдөлмөр эрхлэлтийн статусыг хэлнэ үү?
V172	CL8E	Сүүлийн 7 хоногт эсвэл тогтмол ажилтай бол эрхэлдэг үндсэн ажлын үйл ажиллагааны чиглэл	contin	numeric	Хэрэв сүүлийн 7 хоногт ямар нэг ажил хийсэн бол асуух: (Нэр) сүүлийн 7 хоногт ямар үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй ажил эрхэлсэн бэ? Хэрэв ер нь тогтмол ажилтай бол асуух: (Нэр) ямар үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй ажил эрхэлдэг вэ?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V173	CL5	Сүүлийн 7 хоногт өрхийнхөө хэрэгцээнд зориулан ус зөөх, түлээ түлш бэлтгэх гэх мэт ажил хийсэн эсэх	discrete	numeric	(Нэр) сүүлийн 7 хоногт өрхийнхөө хэрэгцээнд зориулан ус зөөх, түлээ түлш бэлтгэх гэх мэт ажил хийсэн үү?
V174	CL6	Сүүлийн 7 хоногт өрхийнхөө хэрэгцээнд зориулан ус зөөх, түлээ түлш бэлтгэх гэх мэт ажилд зарцуулсан нийт цаг	discrete	numeric	(Нэр) сүүлийн 7 хоногт өрхийнхөө хэрэгцээнд зориулан ус зөөх, түлээ түлш бэлтгэх гэх мэт ажилд нийт хэдэн цаг зарцуулсан бэ?
V175	CL9	Сүүлийн 7 хоногт дэлгүүр явах, гэр цэвэрлэх, хувцас угаах, хоол хийх, хүүхэд, өндөр настан, өвчтэй хүн асрах гэх мэт гэрийн ажилд тусалсан эсэх	discrete	numeric	(Нэр) сүүлийн 7 хоногт дэлгүүр явах, гэр цэвэрлэх, хувцас угаах, хоол хийх, хүүхэд, өндөр настан, өвчтэй хүн асрах гэх мэт гэрийн ажилд тусалсан уу?
V176	CL10	Сүүлийн 7 хоногт гэрийн ажилд зарцуулсан нийт цаг	discrete	numeric	(Нэр) сүүлийн 7 хоногт гэрийн ажилд нийт хэдэн цаг зарцуулсан бэ?
V177	HH5_Y	Ярилцлага авсан он	discrete	numeric	
V178	HH5_M	Ярилцлага авсан сар	discrete	numeric	
V179	HH5_D	Ярилцлага авсан өдөр	contin	numeric	
V180	HH6	Байршил	discrete	numeric	
V181	HH7A	Аймаг/ нийслэлийн нэр, код	discrete	numeric	
V182	HH7B	Сум/ дүүргийн нэр, код	contin	numeric	
V183	HH7C	Баг/ хорооны нэр, код	contin	numeric	
V184	HH7D	Хэсгийн нэр, код	discrete	numeric	
V185	MEMAGE	Насны ангилал	discrete	numeric	
V186	DEPEND	Хүн ам зүйн ачаалал тооцох насны бүлэг	discrete	numeric	
V187	AGE017	Хүүхдүүд ба насанд хүрэгчид	discrete	numeric	
V188	MLINE	Эх/асран хамгаалагчийн мөрийн дугаар	discrete	numeric	
V189	FLINE	Төрсөн эцгийн мөрийн дугаар	discrete	numeric	
V190	HH11	Нийт өрхийн гишүүдийн тоо	discrete	numeric	
V191	melevel	Эхийн боловсрол	discrete	numeric	
V192	felevel	Эцгийн боловсрол	discrete	numeric	
V193	helevel	Өрхийн тэргүүлэгчийн боловсрол	discrete	numeric	
V194	schage	Календарийн жил дэх нас	discrete	numeric	
V195	HHSEX	Өрхийн тэргүүлэгчийн хүйс	discrete	numeric	
V196	region	Бүс нутаг	discrete	numeric	
V197	area	Хот, хөдөө	discrete	numeric	
V198	religion	Өрхийн тэргүүлэгчийн шашин шүтлэг	discrete	numeric	
V199	ethnicity	Өрхийн тэргүүлэгчийн яс үндэс	discrete	numeric	
V200	hhweight	Өрхийн түүврийн жин	contin	numeric	
V201	wscore	Аж байдлын түвшний оноо	contin	numeric	
V202	windex5	Аж байдлын түвшин	discrete	numeric	

Women

Агуулга	Энэхүү файл нь Хүүхэд хөгжил 2010 судалгааны Үндэсний статистикийн хорооны даргын 2010 оны 01/87 тоот тушаалаар батлагдсан маягт ХХС4-2-ийн "15-49 НАСНЫ ЭМЭГТЭЙН АСУУЛГА"-ын тухайн эмэгтэйн хаягийн мэдээллийн(WM1-WM11), ярилцлага өгч буй эмэгтэйн ерөнхий мэдээллийн(WB1-WB7),Олон нийтийн мэдээллийн хэрэгслэлийн хүртээмж болон мэдээлэл, харилцааны технологийн хэрэглээний талаарх мэдээллийн(MT2-MT11),Хүүхдийн эндэгдлийн мэдээллийн (CM1-CM13), Хүсээгүй жирэмслэлтийн мэдээллийн (DB1-DB3_N), Эх, нялхсын эрүүл мэндийн талаарх мэдээллийн (MN1-MN27_X), Өвчлөлийн шинж тэмдэгийн талаарх мэдээллийн (IS2-IS2_Z)8Жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгслэлийн мэдлэг, хэрэглээний мэдээллийн (CP1-CP3B_X), Жирэмснээс сэргийлэх арга, хэрэгслийн хэрэгцээний талаарх мэдээллийн (UN2-UN13_N), Гэрлэлтийн байдлын талаарх мэдээллийн (MA1-MA9), Гэр бүлийн хүчирхийлэлд хандах хандлагын талаарх мэдээллийн (DV1_A-DV6_D), Бэлгийн харьцааны төлөвшлийн мэдээллийн(SB1B-SB15), ХДХВ/ДОХ-ын талаарх мэдлэг,хандлагын тухай мэдээллийн(HA1-HA27), Тамхи, согтууруулах ундааны хэрэглээний мэдээллийн(TA1-TA16), Амьдралын сэтгэл ханамжийн талаарх мэдээллийн(LS2-LS12) хэсгүүд болон өрхийн тэргүүлэгчийн хүйс,боловсрол,яс үндэс, шашин шүтлэг, хүн ам зүйн ачаалал ба аж байдлын түвшин тооцох зэрэг тооцооны нэмэлт үзүүлэлтүүдийн мэдээллийг агуулсан. Тус файл нь 293 хувьсагчтай.
Тохиолдолууд	9599
Хувьсагч	293
Бүтэц	Төрөл: relational Түлхүүрүүд: HH1(Түүвэрлэгдсэн нэгжийн дугаар), HH2(Өрхийн дугаар), LN(Мөрийн дугаар)
Хувилбар	
Гүйцэтгэгч	
Missing Data	A standard coding system and formatting has been used throughout the questionnaires. For example, the codes 9, 99, 999 and 9999 are used for "NA" responses as well as missing and the codes 8, 98, 998 and 9998 are used for "DK" responses but are not used for missing if the measure of the variables are not scale . The codes 6, 96, 996 and 9996 are reserved for "Other" responses.

Хувьсагчид

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V203	HH1	Түүвэрлэгдсэн нэгжийн дугаар	contin	numeric	
V204	HH2	Өрхийн дугаар	contin	numeric	
V205	LN	Мөрийн дугаар	discrete	numeric	
V206	WM1	Түүвэрлэгдсэн нэгжийн дугаар	contin	numeric	
V207	WM2	Өрхийн дугаар	contin	numeric	
V208	WM4	Эмэгтэйн мөрийн дугаар	discrete	numeric	
V209	WM5	Ярилцлага авагчийн нэр, дугаар	contin	numeric	
V210	WM6_Y	Ярилцлага авсан он	discrete	numeric	
V211	WM6_M	Ярилцлага авсан сар	discrete	numeric	
V212	WM6_D	Ярилцлага авсан өдөр	contin	numeric	
V213	WM7	Ярилцлагын үр дүн	discrete	numeric	
V214	WM8	Хянагчийн нэр, дугаар	discrete	numeric	
V215	WM9	Шивэлтийн операторын нэр, дугаар	discrete	numeric	
V216	WM10_H	Ярилцлага эхэлсэн уаг	discrete	numeric	
V217	WM10_M	Ярилцлага эхэлсэн минут	discrete	numeric	
V218	WM11_H	Ярилцлага дууссан цаг	discrete	numeric	
V219	WM11_M	Ярилцлага дууссан минут	discrete	numeric	

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V220	WB1_Y	Төрсөн он	discrete	numeric	Та төрсөн оноо хэлнэ үү?
V221	WB1_M	Төрсөн сар	discrete	numeric	Та төрсөн сараа хэлнэ үү?
V222	WB1_D	Төрсөн өдөр	discrete	numeric	Та төрсөн өдрөө хэлнэ үү?
V223	WB2	Нас	contin	numeric	Та хэдэн настай вэ?
V224	WB3	Цэцэрлэгт хүмүүжиж/ сургуульд сурч эсэх	discrete	numeric	Та цэцэрлэгт хүмүүжиж/ сургуульд сурч байсан уу?
V225	WB4	Сурч байсан сургуулийн хамгийн дээд шат	discrete	numeric	Та хамгийн дээд тал нь аль шатны сургуульд сурсан бэ?
V226	WB5	Төгссөн сургуулийн хамгийн дээд талын анги/курс	discrete	numeric	Та хамгийн дээд тал нь энэ шатны сургуулийн хэддүгээр анги/ курсыг төгссөн бэ?
V227	WB7	Өгсөн өгүүлбэрийг унших	discrete	numeric	Та надад энэ өгүүлбэрийг уншиж өгнө үү?
V228	WB7A	Унших өгүүлбэрийг бичиж өгөх	discrete	numeric	Та надад миний одоо унших өгүүлбэрийг бичиж өгнө үү?
V229	MT2	Сонин, хэвлэл их уншдаг эсэх	discrete	numeric	Та сонин, хэвлэл хэр их уншдаг вэ? Бараг өдөр бүр үү, долоо хоногт наад зах нь 1 удаа юу, сард наад зах нь 1 удаа юу эсвэл огт уншдаггүй юу?
V230	MT3	Радио, FM хэр их сонсдог	discrete	numeric	Та радио, FM хэр их сонсдог вэ? Бараг өдөр бүр үү, долоо хоногт наад зах нь 1 удаа юу, сард наад зах нь 1 удаа юу эсвэл огт сонсдоггүй юу?
V231	MT4	Телевиз хэр их үздэг	discrete	numeric	Та телевиз хэр их үздэг вэ? Бараг өдөр бүр үү, долоо хоногт наад зах нь 1 удаа юу, сард наад зах нь 1 удаа юу эсвэл огт үздэггүй юу?
V232	MT6	Компьютер хэрэглэж үзсэн эсэх	discrete	numeric	Та компьютер хэрэглэж үзсэн үү?
V233	MT7	Сүүлийн 12 сард компьютер хэрэглэсэн	discrete	numeric	Та сүүлийн 12 сард компьютер хэрэглэсэн үү?
V234	MT8	Сүүлийн 1 сард компьютер хэр их хэрэглэсэн тухай	discrete	numeric	Та сүүлийн 1 сард компьютер хэр их хэрэглэсэн бэ? Бараг өдөр бүр үү, долоо хоногт наад зах нь 1 удаа юу, сард наад зах нь 1 удаа юу эсвэл огт хэрэглээгүй юу?
V235	MT9	Интернэт хэрэглэж үзсэн эсэх	discrete	numeric	Та интернэт хэрэглэж үзсэн үү?
V236	MT10	Сүүлийн 12 сард интернэт хэрэглэсэн эсэх	discrete	numeric	Та сүүлийн 12 сард интернэт хэрэглэсэн үү?
V237	MT11	Сүүлийн 1 сард интернэт хэр их хэрэглэсэн	discrete	numeric	Та сүүлийн 1 сард интернэт хэр их хэрэглэсэн бэ? Бараг өдөр бүр үү, долоо хоногт наад зах нь 1 удаа юу, сард наад зах нь 1 удаа юу эсвэл огт хэрэглээгүй юу?
V238	CM1	Хүүхэд төрүүлж байсан эсэх	discrete	numeric	Та хүүхэд төрүүлж байсан уу?
V239	CM2_Y	Анхны хүүхдээ төрүүлсэн он	discrete	numeric	Та анхны хүүхдээ хэдэн онд төрүүлсэн бэ?
V240	CM2_M	Анхны хүүхдээ төрүүлсэн сар	discrete	numeric	Та анхны хүүхдээ хэдэн сард төрүүлсэн бэ?
V241	CM2_D	Анхны хүүхдээ төрүүлсэн өдөр	discrete	numeric	Та анхны хүүхдээ хэдний өдөр төрүүлсэн бэ?
V242	CM3	Анхны хүүхдээ төрүүлснээс хойшхи бүтэн жилийн тоо	discrete	numeric	Та хэдэн жилийн (бүтэн жилээр) өмнө анхны хүүхдээ төрүүлсэн бэ?
V243	CM4	Төрүүлсэн хүүхдүүдээс чинь одоо хамт амьдардаг хүүхэд байгаа эсэх	discrete	numeric	Таны төрүүлсэн хүүхдүүдээс чинь одоо тантай хамт амьдардаг хүүхэд байгаа юу?
V244	CM5_A	Хамт амьдардаг хүүгийн тоо	discrete	numeric	Одоо тантай хамт амьдардаг хүүхдүүдээс чинь хэд нь хүү вэ?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V245	CM5_B	Хамт амьдардаг охидын тоо	discrete	numeric	Одоо тантай хамт амьдардаг хүүхдүүдээс чинь хэд нь охин вэ?
V246	CM6	Төрүүлсэн хүүхдүүдээс чинь одоо амьд сэрүүн хэдий ч тантай хамт амьдардаггүй хүүхэд байгаа эсэх	discrete	numeric	Таны төрүүлсэн хүүхдүүдээс чинь одоо амьд сэрүүн хэдий ч тантай хамт амьдардаггүй хүүхэд байгаа юу?
V247	CM7_A	Амьд сэрүүн хэдий ч хамт амьдардаггүй хүүгийн тоо	discrete	numeric	Одоо амьд сэрүүн хэдий ч тантай хамт амьдардаггүй хүүхдүүдээс чинь хэд нь хүү вэ?
V248	CM7_B	Амьд сэрүүн хэдий ч хамт амьдардаггүй охидын тоо	discrete	numeric	Одоо амьд сэрүүн хэдий ч тантай хамт амьдардаггүй хүүхдүүдээс чинь хэд нь охин вэ?
V249	CM8	Төрүүлсэн хүүхдүүдээс нь амьд төрөөд эндсэн хүүхэд байгаа эсэх	discrete	numeric	Таны төрүүлсэн хүүхдүүдээс чинь эндсэн хүүхэд байгаа юу?
V250	CM9_A	Төрүүлсэн хүүхдүүдээс нь амьд төрөөд эндсэн хэдэн хүү байсан тухай	discrete	numeric	Төрүүлсэн хүүхдүүдээс нь амьд төрөөд эндсэн хэдэн хүү байсан бэ?
